



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 11/106

Мандалговь

“Аймгийн ЗДТГ-ын "E-Mongolia"
төрийн үйлчилгээний цэгийн засварын зураг,
төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний
ажлыг хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Аймгийн ЗДТГ-ын "E-Mongolia" төрийн үйлчилгээний цэгийн тохижилт, баруун, зүүн коридорын засварын ажлын зураг, төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

М.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Ч.Лхагваа (Төсөв төсөл ХХК-ийн архитектор)

2. Аймгийн ЗДТГ-ын "E-Mongolia" төрийн үйлчилгээний цэгийн тохижилт, баруун, зүүн коридорын засварын ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Түвшинжаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ДОРЖБАТ



4822150243